

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах төмөр замын барилга, байгууламжид Төмөр замын тээврийн тухай хуульд заасны дагуу барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулахдаа Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйл болон энэ журмыг баримтална.

Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Төмөр замын тээврийн тухай хууль төмөр замын тээврийн дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар ойлгоно.

Энэ журмын зохицуулалтад хамаарахгүй төмөр замын бусад дагалдах дэд бүтцийн барилга байгууламж нь Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулагдана.

Төмөр замын барилга байгууламжийн барилгын ажлыг Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, үндэсний стандарт норм норматив, зураг төсөл, техникийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

Хоёр. Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх

2.1. Захиалагч төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн хүсэлтийг дараах байгууллага, албан тушаалтанд гаргана:

2.1.1. Төмөр замын суурь бүтцийн замын барилга байгууламж шинээр барих өргөтгөх, авто зам, дэд бүтэц, бусад инженерийн шугам сүлжээг огтлолцуулах, ажлын зөвшөөрлийн хүсэлтийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх);

2.2. Хүсэлт гаргагч нь төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн хүсэлтэд энэ журмын 7 дугаар хавсралтад заасан баримт бичгийг хавсаргасан байна.

2.3. Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

2.4. Эрх бүхий байгууллага төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн хүсэлтийг хянах явцад шаардлагатай бол холбогдох байгууллагаас тодруулга авч болно.

2.5. Суурь бүтэц, салбар замын барилгын ажлын зөвшөөрөл олгоход магадлагдсан зураг төсөл, тусгай зөвшөөрөл, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, техникийн

нөхцөлийн дүгнэлтийг тус тус үндэслэн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохтой холбоотой ажлыг шийдвэрлэнэ.

Гурав. Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох

3.1. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан гэрчилгээгээр баталгаажуулан олгоно.

3.2. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2 хувь үйлдэж, захиалагчид 1 хувийг олгож, үлдсэн хувийг архивт хадгална.

3.4. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу хугацаа сунгалтыг тэмдэглэж, бүртгэл хөтөлнө.

3.5. Захиалагч барилгын ажлын явцад дараах өөрчлөлт гарсан тохиолдолд Төмөр замын тээврийн тухай хууль болон төмөр замын тээврийн дүрэм, журамд заасны дагуу зохих арга хэмжээг авч, зөвшөөрөл олгосон байгууллагад тухай бүрд нь мэдэгдэнэ.

3.6. Захиалагч байгууллага ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дуусахаас ажлын 10 хоногийн өмнө дараах тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагад сунгах хүсэлтийг хүргүүлнэ. Үүнд:

3.6.1. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон;

3.6.2. Гүйцэтгэгч, техник технологийн хяналт хэрэгжүүлэгч өөрчлөгдсөн;

3.6.3. Гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

3.6.4. Төмөр замын барилга байгууламжийн дээд, доод бүтэц, үндсэн хийц бүтээцэд өөрчлөлт оруулж, зураг төсөл өөрчлөгдсөн;

3.7 Зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлт ирүүлээгүй бол зөвшөөрлийн хугацаа дуусмагц гэрчилгээг хүчингүйд тооцно.

3.8 Захиалагч нь энэхүү журмын 2.3-д заасан зөвшөөрлийн дагуу төмөр замын суурь бүтэц барих, өргөтгөх, ажлыг эрх бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

3.9 Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрөл зохих ёсоор олгогдоогүй үед барилгын ажил гүйцэтгэхгүй.

Дөрөв. Төмөр замын барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзах

4.1. Зөвшөөрөл олгох байгууллага дараах үндэслэлээр төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрөл олгохоос татгалзана:

4.1.1. Баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;

4.1.2. Баримт бичиг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага /захиалагч, техник, технологийн хяналт, гүйцэтгэгч байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, зураг төсөлд магадлал хийгдээгүй төлөвлөлтийн болон норматив баримт бичгийн шаардлагыг зөрчсөн/-д нийцээгүй.

4.2. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэлийг албан бичгээр хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

Тав. Шинээр болон шинэчлэн сайжруулсан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх

5.1. Төмөр замын барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдөх шаардлага үүссэн тохиолдолд гүйцэтгэгч нь батлагдсан зураг төслийг зохиогчийн зөвшөөрлөөр өөрчилж, гүйцэтгэлийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.

5.2. Зураг төслийн өөрчлөлтөөс үүссэн барилга угсралтын зардлыг зураг төсөл зохиогч болон захиалагчийн зөвшөөрлөөр магадлашгүй ажлын зардлаас гаргана.

5.3. Шинээр болон шинэчлэн сайжруулсан төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, угсралтын ажлын дараа түүний бодит байрлал, өндрийн хэмжээг төслийн хэмжээтэй хэрхэн уялдаж байгааг гүйцэтгэлийн хэмжилт, зураг үйлдэх замаар шалгаж баталгаажуулна.

5.4. Шинээр болон шинэчлэн сайжруулсан төмөр замын суурь бүтцийн байр зүйн дэвсгэр зураг, гол бүтээцийн элементүүд, газар доорх инженерийн шугам сүлжээний ажлын зургийн хамт гүйцэтгэлийн зургийг хийлгэж, Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээлгэж өгөх үүргийг гүйцэтгэгч хариуцна.

5.5. Төмөр замын суурь бүтцийг ажлын түр хөдөлгөөнд ашиглах:

5.5.1. Төмөр замын суурь бүтцийг үргэлжлүүлэн барих явцдаа баригдсан төмөр замыг ул шороо, замын чигжээсийг тогтворжуулах зорилгоор түр хөдөлгөөнд /цаашид “ажлын түр хөдөлгөөн” гэх/ ашиглаж болно;

5.5.2. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргаж төмөр замын суурь бүтцийг ажлын түр хөдөлгөөнд ашиглах эсэх шийдвэр гаргана;

5.5.3. Суурь бүтцийг ажлын түр хөдөлгөөнд ашиглах тохиолдолд суурь бүтцийн техникийн байдал нь доорх шаардлагыг хангасан байна;

5.5.3.1. Замын далан, сэтэрхийн налуулгыг тогтворжуулж, ус зайлуулах төхөөрөмж суурилуулсан байх, ул шороог төслийн төвшинд хүргэсэн байх;

5.5.3.2. Хиймэл төхөөрөмж нь түр ашиглалтын хугацаанд энэ хэсгээр явах хөдлөх бүрэлдэхүүнийг тогтоосон хурдаар явуулах нөхцөлийг хангасан байх;

5.5.3.3. Төмөр замын дээд бүтэц нь 20 см-ээс багагүй зузаантай чигжээсний үе дээр тавигдсан байх;

5.5.3.4. Холбоо, дохиоллын байгууламж нь галт тэрэгний хөдөлгөөн зохицуулахад мөн галт тэрэг болон өртөө хоорондын холбоо, дохиололд /өртөөнд сумын постын холбоонд/ ашиглах боломжтой байх;

5.6. Төмөр замын төслийн барилгын ажил дараах шалтгаанаар 1 жилээс дээш хугацаагаар зогссон бол энэ журмын 2.3-д заасны дагуу барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авна.

5.6.1. Салбарын хяналтын болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажлыг зогсоосон;

5.6.2. Техник технологийн хяналтын зөвлөхийн санал дүгнэлтэд үндэслэн захиалагчийн шийдвэрээр ажлыг зогсоосон;

5.6.3. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төслийн ажлыг зогсоосон;

5.7. Төмөр замын барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгчтэй холбоотой асуудал нь барилгын ажлын захиалагчийн дүрмийн дагуу зохицуулагдана.

Зургаа. Шинээр болон шинэчлэн сайжруулсан төмөр замын суурь бүтцийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх, ашиглалтад хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулах

6.1. Захиалагч төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт гаргахдаа Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж, техникийн комиссын үзлэг хийлгэж, дүгнэлтэд заасан зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.

6.2. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

5.2.1. Шинэчлэн сайжруулсан, өргөтгөсөн ажлын барилга байгууламж болон шинээр баригдсан салбар төмөр зам, түүний өргөтгөлийг ашиглалтад оруулах эсэхийг шийдвэрлэнэ;

5.2.2. Төмөр замын суурь бүтцийн дагалдах дэд бүтцийн барилга байгууламжийг тухайн чиглэлийн асуудал хариуцсан байгууллагад хууль дүрэм, журмын дагуу хүсэлт гаргаж байнгын ашиглалтад оруулна;

5.2.3. Орон сууцны барилга, үйлдвэрлэлийн бус (нийгмийн) зориулалттай объектуудыг ашиглалтад хүлээн авахдаа Монгол Улсын хууль тогтоомж болон барилга байгууламжийг хүлээн авах, ашиглалтад оруулах дүрмийг удирдлага болгоно.

6.3. Захиалагч нь төмөр замын барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах хүсэлт гаргахын өмнө энэ журмын 8 дугаар хавсралтад заасан баримт бичгийн бүрдлийг хангасан байна.

6.4. Төрийн захиргааны төв байгууллага нь төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтэд хавсаргасан энэ журмын хавсралт 8-д заасан баримт

бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан бол төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулна.

6.4.1. Төмөр замын тээврийн тухай хуулийн 23.5-д заасан төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтын 2-т заасан бүрэлдэхүүнтэй;

6.4.2. Төмөр замын барилга байгууламж (шинээр барих, шинэчлэх)-ийг ашиглалтад оруулах техникийн комиссыг энэ журмын 3 дугаар хавсралтын 1-д заасан бүрэлдэхүүнтэй;

6.4.3. Салбар замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсгийг энэ журмын 3 дугаар хавсралтын 3-т заасан бүрэлдэхүүнтэй;

6.5. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахад техникийн комиссын үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгасан байна.

6.6. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай комиссын акт дүгнэлт баталгаажсанаар тухайн төмөр зам, замын байгууламжийг ашиглалтад оруулсанд тооцно.

6.7. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулсан хугацаа нь улсын комисс, захиалагч гарын үсэг зурсан өдөр байна.

Долоо. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын чиг үүрэг

7.1. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Төмөр замын тээврийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандарт зураг төсөл, техникийн баримт бичигт заасан шаардлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн шаардлагыг хангасан төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах;

7.1.2. Төмөр замын тээврийн тухай хуульд заасан хяналт хэрэгжүүлэх байгууллагаас хийсэн шалгалтаар төмөр замын барилгын ажлын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан эсэхийг дүгнэх;

7.1.3. Техникийн комиссын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих;

7.1.4. Монгол Улсын стандарт, норм, дүрэм, зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдээгүй буюу чанаргүй хийсэн, техник технологийн захиалагчийн хяналт, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10.2.8-т заасан болон хяналтын байгууллагаас тавьсан шаардлага, техникийн комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд ашиглалтад хүлээн авахыг хойшлуулах, холбогдох байгууллагаар хөндлөнгийн дүгнэлт гаргуулах;

7.1.5. Төмөр замын суурь бүтцийн барилга байгууламж нь зураг төсөлд тусгагдсан байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлууд дутуу хийгдсэн болон огт хийгдээгүй, барилга угсралтын явцад хөрсний гэмтлийн нөхөн сэргээлт

хийгээгүй, хүн, амьтны аюулгүй байдлыг хангаагүй нөхцөлд төмөр замын суурь бүтцийг ашиглалтад хүлээж авахгүй;

7.2. Төмөр замын тээврийн тухай хуулийн 23.3-д заасан техникийн комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.2.1. энэ журмын 7.1-т заасан комисст дэмжлэг үзүүлж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах урьдчилсан дүгнэлт гаргах;

7.2.2. комисс нь мэргэжлийн чиглэл, ажил үүргийн дагуу ажилласан гишүүдийн санал, дүгнэлтийг үндэслэн, олонхын саналаар эцсийн шийдвэрийг гаргах ба энэхүү шийдвэр нь Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байх;

7.2.3. төмөр замын суурь бүтцийн дагалдах барилга байгууламж, түүнд суурилагдсан тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний туршилт тохируулга, зүгшрүүлэлт хийсэн дүгнэлт, баталгаажуулалт, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт хийсэн байдлыг шалгах;

7.2.4. комисс нь шинээр баригдсан, шинэчлэн сайжруулсан төмөр зам нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тохиолдолд бүрэн болон хэсэгчлэн ашиглалтад авах, хөдөлгөөн нээх дүгнэлт гаргах;

7.3. Төмөр замын шинэ, шинэчлэн сайжруулсан суурь бүтцийг өртөө зөрлөг хооронд хэсэгчлэн ашиглалтад хүлээн авч болно.

7.4. Комисс ажилласнаас хойш ажлын 15 хоногийн дотор дүгнэлтийг баталгаажуулна.

Найм. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дүгнэлт гаргах

8.1. Төмөр замын барилга байгууламж, суурь бүтэц, салбар замыг ашиглалтад оруулах комисс (цаашид "Комисс" гэх) нь барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбоотой асуудлыг хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

8.2. Комисс дүгнэлт гаргахын өмнө тухайн барилга байгууламжтай танилцан үзлэг хийж, зөрчил дутагдал илэрсэн бол түүнийг арилгуулахаар захиалагч, гүйцэтгэгчид үүрэг даалгавар өгнө.

8.3. Комиссын нарийн бичгийн дарга комиссын хурлын бэлтгэлийг хангах, гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хурал зохион байгуулах, хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, дүгнэлт үйлдэх ажлыг хариуцах бөгөөд баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан бол комисс ажиллуулах мэдэгдлийг комиссын гишүүдэд тараана.

8.4. Комиссын хурлыг гишүүдийн 80 хувиас доошгүй ирцтэй зохион байгуулна.

8.5. Комиссын үйл ажиллагааг дараах дарааллаар зохион байгуулна:

8.5.1. комисс ажиллахаас өмнө комиссын гишүүдийг томилсон шийдвэр, ирцийг комиссын нарийн бичгийн дарга танилцуулж энэ журмын 8.4-т заасан ирц хангагдсан эсэхийг оролцогчдод мэдээлнэ;

8.5.2. комиссын дарга, гишүүдээс ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна;

8.5.3. комиссын гишүүд шаардлагатай тохиолдолд төмөр замын барилга байгууламжийн болон техникийн баримт бичгийг шалгаж, төслийн талбайтай танилцана;

8.5.4. комиссын гишүүд хариуцсан асуудал тус бүрээр хийж гүйцэтгэх шаардлагатай ажил, нэмэлт мэдээлэл зөвлөмж, саналаа танилцуулах бөгөөд барилга байгууламжийг ашиглалтад оруулах боломжтой эсэх дүгнэлтээ тодорхой мэдэгдэнэ;

8.5.5. комиссын дарга комиссын гишүүдийн олонхын саналд үндэслэн шаардлагатай тохиолдолд хугацаатай үүрэг даалгавар өгнө.

8.6. Комисс ажилласны дараа комиссын гишүүд өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, биелэлт хангагдсан тохиолдолд энэ журмын 6 дугаар хавсралтад заасан үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна.

8.7. Комисс асуудлыг хэлэлцээд зөрчилтэй, шаардлага хангагдаагүй гэж дүгнэсэн бол төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзана.

8.8. Комиссоос төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулахаас татгалзсан дүгнэлт гаргасан, эсхүл комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй бол комиссыг дахин ажиллуулна.

8.9. Захиалагч нь комиссын хууль бус үйлдлийн тухай гомдлыг холбогдох хууль хяналтын байгууллагад гаргаж болно.

8.10. Комиссын гишүүн батлагдсан зураг төсөл болон холбогдох хууль, дүрэм, журам норм дүрмийн шаардлагад нийцэхгүй үүрэг даалгавар өгсөн бол хариуцлагыг өөрөө хүлээнэ.

8.11. Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн энэ журмын 7.4-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

8.11.1. төмөр замын барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт;

8.11.2. энэ журмын 6.6, 7.1-д заасан шаардлага хангаагүй, 8.6-д заасан үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт;

8.12. Энэ журмын 8.8-д заасны дагуу ашиглалтад оруулах комисс, техникийн комиссыг дахин ажиллахтай холбогдох зардлыг гүйцэтгэгч хариуцна.

Ес. Бүртгэл, мэдээлэл

9.1. Улсын комисс хүлээн авсны дараа гүйцэтгэгч байгууллага нь баримт бичгийн бүрдлийг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын дагуу бүрдүүлж захиалагчид хүргүүлнэ. Захиалагч байгууллага нь баримт бичгийг Үндэсний төв архивд хүлээлгэн өгөх ба хувийг төрийн захиргааны төв байгууллага болон төмөр замын тээврийн байгууллагын архивт хадгална.

9.1.1. улсын комиссын дүгнэлтэд шинээр барьж байгуулсан, шинэчлэн сайжруулсан төмөр замын барилга байгууламжийг улсын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэх тухай тусгах;

9.2. Ашиглалтад оруулсан төмөр замын барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичгийг архивт хүлээлгэн өгч, Төмөр замын тээврийн тухай хуулийн 10.2.14-т заасны дагуу мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг хүргүүлэх ажлыг захиалагч хариуцна.

9.3. Комиссын дүгнэлтийг кадастрын цахим мэдээллийн санд оруулах зорилгоор шаардлагатай мэдээллийг аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалт, газрын харилцааны асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх ажлыг захиалагч хариуцна.

Арав. Хариуцлага

10.1 Энэ журмыг зөрчсөн хуулийн этгээдэд Төмөр замын тээврийн тухай хууль Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

___о0о___

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 1 дүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

20 ... оны ... сарын
..... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

1. Төмөр замын барилга байгууламжийн мэдээлэл:

Төмөр замын барилга байгууламж, объектын нэр:.....

Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц:

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/

Зургийн шифр:..... Магадлалын дугаар:

Зөвшөөрөл олгосон үе шатны ажлын нэр:.....

Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:.....

2. Газар олгосон шийдвэрийн мэдээлэл:

Газар олгосон шийдвэр (захирамж): 20 оны сарын өдрийн дугаар

Байршил: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/

3. Гүйцэтгэгч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:.....

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/

Холбоо барих: цахим хаяг, утасны дугаар

4. Захиалагч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/

Холбоо барих: цахим хаяг, утасны дугаар

5. Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:.....

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/
Холбоо барих: цахим хаяг, утасны дугаар

6. Зураг төсөл зохиогч байгууллагын талаарх мэдээлэл:

Байгууллагын оноосон нэр:
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:
Байгууллагын тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар:
Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж
Холбоо барих: цахим хаяг, утасны дугаар

7. Онцгойлон заах нөхцөл:

8. Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд:

9. Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл:

10. Зөвшөөрөл олгосон албан тушаалтны мэдээлэл:
байгууллагын нэр, албан тушаал,
овог нэр, гарын үсэг, (тамга, тэмдэг)

[illegible]

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах журмын 2 дугаар хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ
ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ**

1. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн хугацааг сунгах шалтгаан:
2. Төмөр замын барилга байгууламжийн ажлын төлөв байдал: үе шат, гүйцэтгэсэн ажлын нэр, төрөл;
3. Төмөр замын барилгын ажил гүйцэтгэх хугацаа:
4. Төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгасан ажилтны мэдээлэл: байгууллагын нэр, албан тушаал, овог нэр, / / гарын үсэг, (тамга, тэмдэг)

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 3 дугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Төмөр замын тээврийн тухай хуулийн 23.3-д заасан төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах Техникийн комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга: -Төмөр замын асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллагын нэгжийн дарга.

Гишүүд:

- Хяналтын чиглэлийн нэгжийн төлөөлөл;

-Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (салбар тус бүр нэг);

-Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөл;

-Техник, технологийн хяналтын төлөөлөл;

-Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл (тухай чиглэлийн дагуу ажил хийгдсэн тохиолдолд);

-Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);

-Захиалагч, захиалагчийн хяналтын байгууллагын төлөөлөл;

-Ашиглалт хариуцсан байгууллагын төлөөлөл;

-Байгаль орчны асуудал хариуцсан орон нутгийн төлөөлөл;

-Архивын байгууллагын төлөөлөл;

2. Төмөр замын тээврийн тухай хуулийн 11.1.5, 23.5-д заасан төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:

-Холбогдох төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга.

Гишүүд:

-Салбарын хяналтын байгууллагын төлөөлөл;

-Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл

-Захиалагч байгууллагын төлөөлөл

-Ашиглагч байгууллагын төлөөлөл

- Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);

-Архивын байгууллагын төлөөлөл.

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

3. Төмөр замын тээврийн тухай хуулийн 32-д заасан салбар замыг /шинээр барих өргөтгөх, шинэчлэх/ ашиглалтад оруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

- Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл;

Гишүүд:

- Суурь бүтэц эзэмшигч байгууллагын төлөөлөл;

- Захиалагч байгууллагын төлөөлөл;

- Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);
- Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;
- Шаардлагатай тохиолдолд инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл;

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах журмын 4 дүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДҮГНЭЛТ

Дугаар...

20...оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын аймаг, /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/-ны нутаг дэвсгэрт баригдсан чиглэлийн
хүчин чадал бүхий зэрэглэлийн зориулалттай төмөр замын
барилга байгууламжид сайдын 20 ... оны сарын ... -ны
өдрийн дугаар шийдвэрээр байгуулагдсан хүний бүрэлдэхүүнтэй төмөр замын
барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс 20 ... оны сарын ... -
ны өдрөөс эхлэн хоногийн хугацаанд ажиллан
төмөр замын барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт
хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн гэрчилгээ:
..... огноо, дугаар;

2.2. Төмөр замын барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар:

2.3. Захиалагч: /Иргэний хувьд/, харьяалал /аль улсын/,
ургын овог, эцэг /эх/-ийн нэр, нэр

Регистрийн дугаар:

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/, баг
/хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар

Холбоо барих утас: Цахим хаяг:.....

/Хуулийн этгээдийн хувьд/: оноосон нэр

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
баг /хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа,
хаалга/-ны дугаар

Холбоо барих утас: Цахим хаяг:.....

2.4. Төмөр замын барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгч: оноосон
нэр

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:

Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар:

Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/, баг
/хороо/, гудамж /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны
дугаар

Холбоо барих утас: Цахим хаяг:.....

2.5. Төмөр замын барилга байгууламжийн ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага:
 оноосон нэр
 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:
 Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
 баг /хороо/, гудамж
 /хороолол/, байр /хашаа, хаалга/-ны дугаар
 Холбоо барих утас: Цахим хаяг:.....

2.6. Төмөр замын барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:
 оноосон нэр,
 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,
 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар:
 Хаяг: аймаг /нийслэл/, сум
 /дүүрэг/, баг /хороо/, гудамж /хороолол/, байр
 /хашаа, хаалга/-ны дугаар
 Холбоо барих утас: Цахим хаяг:.....

2.7. Төмөр замын барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:
 оноосон нэр
 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:
 Хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
 баг /хороо/, гудамж /хороолол/,
 байр /хашаа, хаалга/-ны дугаар
 Холбоо барих утас: Цахим хаяг:.....

2.8. Төмөр замын барилга байгууламжийн төлөв байдал:

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү хүчин чадал бүхий зэрэглэлийн зориулалттай төмөр замын барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь: (доорх сонголтоос дугуйлах)

☐ Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах

-Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.6 дахь заалтад заасан шаардлагыг хангаж, барилгын ажлын зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

☐ Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах

-Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.6 дахь заалтад заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажлын зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

-Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.2. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а). Төмөр замын барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах, зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах, уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Суурь бүтэц эзэмшигч байгууллагад:

а). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б). Төмөр замын барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в). Төмөр замын барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал болон төмөр замын барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. чиглэлийн жилд хүчин чадал бүхий зэрэглэлийн төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: ()

Нарийн бичгийн дарга: ()

Гишүүд: ()

***Энэ журмын 7 дугаар хавсралтын хамт хүчинтэй.

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 5 дугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ТЕХНИКИЙН КОМИССЫН ДҮГНЭЛТ

Дугаар...

20...оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын аймаг, /нийслэл/, сум /дүүрэг/, баг /хороо/-ны нутаг дэвсгэрт баригдсан чиглэлийн хүчин чадал бүхий зэрэглэлийн зориулалттай төмөр замын барилга байгууламжид сайдын 20 ... оны сарын ... -ны өдрийн дугаар шийдвэрээр байгуулагдсан ... хүний бүрэлдэхүүнтэй төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах Техникийн комисс 20 ... оны сарын ... -ны өдрөөс эхлэн хоногийн хугацаанд ажиллан төмөр замын барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Төмөр замын барилга байгууламжийн ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: огноо, дугаар;

2.2. Төмөр замын барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ;

2.3. Захиалагч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Холбоо барих утас	Цахим шуудан

2.4. Төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар	Холбоо барих утас	Цахим шуудан

2.5. Төмөр замын барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн	Хаяг	Барилгын ажил	Холбоо барих утас	Цахим шуудан

	гэрчилгээний дугаар		гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар		

2.6. Төмөр замын барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Зураг төслийн тусгай зөвшөөрлийн дугаар	Холбоо барих утас	Цахим шуудан

2.7. Төмөр замын барилга байгууламжийн суурь бүтэц эзэмшигч байгууллага:

Байгууллагын нэр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Тусгай зөвшөөрлийн дугаар	Холбоо барих утас	Цахим шуудан

2.8. Төмөр замын барилга байгууламжийн төлөв байдал:

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү чиглэлийн хүчин чадал бүхий зэрэглэлийн зориулалттай төмөр замын барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

(Доорх сонголтоос сонгох)

- ☐ Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулах

-Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.6 дахь заалтад заасан шаардлагыг хангаж, барилгын ажлын зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

- ☐ Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг ажиллуулахаас татгалзах

-Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.6 дахь заалтад заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажлын зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

-Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.2. Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а). улсын комисс ажилласны дараа төмөр замын барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах, зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах, уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Суурь бүтэц эзэмшигч байгууллагад даалгах нь:

а). Төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах, зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б). Төмөр замын барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в). Төмөр замын барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Техникийн комиссын дүгнэлт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын жагсаалт ... хуудас материал, үүрэг даалгаврын биелэлтийн хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материал, зураг төслийн шифр дугаарын жагсаалт -ыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. чиглэлийн жилд хүчин чадал бүхий зэрэглэлийн төмөр замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: ()

Нарийн бичгийн дарга: ()

Гишүүд: ()

***Энэ журмын 7 дугаар хавсралтын хамт хүчинтэй.

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 6 дугаар хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ГИШҮҮНИЙ САНАЛЫН ХУУДАС**

Барилга байгууламжийн нэр:
Харъяа байгууллага:
Албан тушаал:
Комиссын гишүүний нэр:

Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар	Биелэлт
Шийдвэр:	
Гарын үсэг: /Тамга, тэмдэг/ Гарын үсгийн тайлал / Огноо:	Гарын үсэг: /Тамга, тэмдэг/ Гарын үсгийн тайлал / Огноо:

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 7 дугаар хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ,
ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ, БАРИМТЫН
ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх бичиг, баримт
А. Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт	
1	Гүйцэтгэгч байгууллагын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг
2	Гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ болон төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийн хуулбар
3	Төмөр замын барилга байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ
4	Улаан шугам хүлээлцсэн акт
5	Магадлал хийгдсэн тухайн төмөр замын барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл, экспертизийн дүгнэлт
6	Төмөр замын барилга байгууламжийн барилга угсралтын ажилд техник, технологийн хяналт гүйцэтгэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ
7	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс газар олгосон шийдвэр, техникийн нөхцөлүүд
8	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, шаардлагатай бол байгаль орчинд нөлөөлөх байдлыг албажуулсан нарийвчилсан үнэлгээ
9	Архиологи, палеонтологи, угсаатны зүйн судалгааны тайлан /зураг төслийн шатанд хийгдсэн тохиолдолд/
Б. Төмөр замын барилга байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт	
1	Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн гүйцэтгэгчийн албан хүсэлт
2	Ажил зогсоох шийдвэр гаргасан холбогдох эрх бүхий байгууллагын ажил үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр, дүгнэлт
3	Зөрчил, доголдлыг арилгасан тухай баримт, гүйцэтгэсэн ажлын тайлан

Төмөр замын барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журмын 8 дугаар хавсралт

ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн жагсаалт
1	Төмөр замын суурь бүтэц барьж байгуулах тухай Улсын Их Хурлаас баталсан тогтоол, шийдвэрийн албан ёсоор баталгаажсан эрх зүйн баримт бичгийн хуулбар
2	Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон Төрийн захиргааны байгууллагын холбогдох шийдвэр эрх зүйн баримт бичиг
3	Бүтээн байгуулалттай холбоотой Улсын Их хурал, Засгийн газар, Төрийн захиргааны байгууллагын холбогдох шийдвэр эрх зүйн баримт бичгийн хуулбарын эмхэтгэл
4	Тухайн барилга байгууламжийг барихтай холбоотой тусгай зөвшөөрлийн хуулбар
5	Захиалагч, зөвлөх үйлчилгээ эрхлэгч, ерөнхий гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
6	Бүтээн байгуулалтын ажлын нэгдсэн товч тайлан
7	Улаан шугам хүлээлцсэн акт
8	Суурь бүтцийн барилгын ажлын үе шатны гүйцэтгэлийн тайлан, талбайн улаан дэвтэр
9	Барилга угсралтын явцын ажил шалгуулах хүсэлт
10	Засаг даргын газар олгосон захирамж, газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, түүнтэй адилтгах баримт бичиг буюу Засгийн газрын тогтоол
11	Гол зам, өртөө зөрлөгийн зам, замын байгууламж, дохиолол холбоо, эрчим хүчний ажлын гүйцэтгэлийн зураг
12	Замын байдал хэмжсэн тайлан (Зам, хэмжигч, сэв шалгах вагоны тайлан)
13	Техник ашиглалтын түвшин тогтоох, чанар байдлын дүгнэлт
14	Суурь бүтцийн бүрдэл хэсгийн тоног төхөөрөмж угсарсан акт, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилуулсан эсэхэд хийсэн туршилтын дүгнэлт
15	Захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт
16	Зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт
17	Суурь бүтцийн барилга байгууламжийн хийц, бүтээцийн өөрчлөлтийн зураг төсөл, зураг төсөл зохиогчийн зөвшөөрөл, магадлалын дүгнэлт
18	Ил, далд ажлын акт (зам, замын байгууламж, гүүр хоолой, дохиолол холбоо, эрчим хүч, барилга байгууламж)
19	Замын паспортын материал (Замын техникийн байдлын тодорхойлолт, дээд бүтцийн материалын тоо ширхэг гэх мэт)
20	Гүүр, хоолойн паспорт (Техникийн үндсэн тодорхойлолт, километрийн байршил, схем зураг)
21	Эрчим хүчний хангамжийн схем зураг, паспорт, холбогдох дүгнэлтүүд
22	Дохиолол холбооны схем зураг, паспорт, холбогдох дүгнэлтүүд, хамаарал шалгасан хүснэгт
23	Өртөө, зөрлөгүүдийн техник захирамжийн акт
24	Өртөө зөрлөгүүдийн барилга байгууламж болон техникийн зориулалттай барилга байгууламжийн гүйцэтгэлийн зураг төсөл, холбогдох дүгнэлтүүд

25	Онцгой байдлын газраас гаргасан дүгнэлт
26	Лабораторийн туршилт шинжилгээний дүгнэлт
27	Геодезийн гүйцэтгэлийн байр зүйн зураг, тайлан
28	Инженер геологи судалгааны тайлан
29	Археологийн авран хамгаалах ажлын тайлан
30	Төмөр замын чигийн дагуу хийгдсэн ус зүйн судалгааны тайлан
31	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан
32	Засаг даргын газар олгосон захирамж, карьеруудын нөхөн сэргээсэн актууд (Байгаль орчны Улсын байцаагчаар баталгаажуулсан)
33	Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн зам, замын байгууламжийн чанар байдлын талаар гаргасан нэгдсэн дүгнэлт
34	Нийт барилга угсралтын хугацаанд Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын эмхэтгэл ба түүний тайлан, тайлбарын хамт
35	Барилга угсралтын хэрэгжилтийн явцад салбар яам, салбарын хяналтын газар болон мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын зүгээс барилгын ажлын явцад хийсэн Төрийн хяналт шалгалтын дагуу өгөгдсөн үүрэг даалгавар, албан шаардлагын биелэлтийн тайлан
36	Барилга угсралтын хугацаанд Орон нутгийн удирдлагын байгууллагаас хандсан албан тоот, захирамж болон бусад албан баримт бичгүүдийн эмхэтгэл
37	Суурь бүтэц ашиглагч, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийг тогтоон, шийдвэрлэсэн баримт бичгийн хуулбар
38	Техникийн комисс, Улсын комиссын акт, хэрэгжүүлэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайлан
39	Улсын комиссын ажиллах үед салбарын онцлогоос шалтгаалсан нэмэлт баримт бичиг